



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2014 оны 03 сарын 12 өдөр

Дугаар 91

Улаанбаатар хот

Үнэт цаасны арилжаа, төлбөр тооцооны  
горимд авах зарим арга хэмжээний тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.1.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 63.1.4, 63.1.7, 63.1.11 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Үнэт цаасны арилжааг идэвхижүүлэх, хөрөнгө оруулагчдын үнэт цаасны арилжаанд оролцох эргэлтийг сайжруулах нөхцлийг бүрдүүлэх зорилгоор үнэт цаасны арилжааны төлбөр тооцоог арилжаа хийгдсэн өдрөөс хойш ажлын нэг өдөрт багтаан /Т+1/ гүйцэтгэх нөхцлийг судалж, шаардлагатай өөрчлөлт, тохируулгыг “Миллениум Ай Ти” системд хийж, туршилтын ажиллагааг зохион байгуулж, үр дүнг 2014 оны 3 дугаар сард багтаан Хорооны хуралдаанд танилцуулахыг Үнэт цаасны газар /Б.Саруул/, “Монголын хөрөнгийн бирж” ХК /Д.Болормаа/, “ҮЦТТТХТ” ХХК /Т.Гандулам/-д тус тус үүрэг болгосугай.

2. “Үнэт цаасны төлбөр тооцоог Т+3 системээр гүйцэтгэх түр журам”, “Төлбөрийн баталгааны сангийн журам”-д харилцагч үнэт цаасны төлбөр гүйцэтгэх банкыг өөрөө чөлөөтэй сонгох нөхцлийг бүрдүүлэх болон холбогдох бусад чиглэлээр өөрчлөлт оруулж, Хорооны хуралдаанд танилцуулахыг Үнэт цаасны газар /Б.Саруул/, “Монголын хөрөнгийн бирж” ХК /Д.Болормаа/, “ҮЦТТТХТ” ХХК /Т.Гандулам/, Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо /Ж.Цэдэнрагчаа/-д тус тус даалгасугай.

3. Брокерийн компани нь төлбөр гүйцэтгэгч банкинд харилцагчийн нэгдсэн данс нээж, харилцагчийн номинал дансаар дамжуулан арилжаанд оролцох боломжтой эсэх талаар судалгаа хийж, Хорооны хуралд 2014 оны 3 дугаар сард багтаан танилцуулахыг Үнэт цаасны газар /Б.Саруул/, “Монголын хөрөнгийн бирж” ХК /Д.Болормаа/, “ҮЦТТТХТ” ХХК /Т.Гандулам/, Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо /Ж.Цэдэнрагчаа/-д тус тус үүрэг болгосугай.

4. “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн гишүүнчлэлийн журам болон гишүүнтэй байгуулах гэрээний нөхцлийг гишүүдийн төлөөлөлтэй хамтран боловсруулж, шинэчлэн батлахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Д.Болормаа/-д үүрэг болгосугай.

5. Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаа явуулах нөхцөл /модул/-ийг “Миллениум Ай Ти” системд суурилуулах ажлыг гүйцэтгэж, энэ талаар Хороонд 2014 оны 4 дүгээр сарын

000093

15-ны өдрийн дотор тайлагнахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Д.Болормаа/-д үүрэг болгосугай.

6. Үнэт цаасны төлбөр тооцоо гүйцэтгэх банкинд данс нээхтэй холбоотой харилцааг хялбар, уян хатан болгох чиглэлээр судалгааг гаргаж, Монголбанктай хамтарч хэрэгжүүлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-д даалгасугай.

7. Нийт брокерийн компаниудад олон улсын нийтлэг жишиг болон өөрийн орны онцлогт тохирсон дотоод бүртгэлийн систем /Back office/-ийн нөхцөл, шаардлага болон түүний санхүүжилтийн төслийг боловсруулж, Хороонд танилцуулахыг Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо /Ж.Цэдэнрагчаа/-д даалгасугай.

8. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА  Д.БАЯРСАЙХАН